



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 7 сарын 9 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

“Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Е-Моние” ХК /Б.Мөнхбаяр/-д даалгасугай.


1/ Энэхүү тушаалын 1-д заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж Хороонд мэдэгдэх;

2/ Оноосон нэрийн өөрчлөлтийг ажлын хоёр хоногт багтаан хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутам хэвлэгдэн гардаг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, баримтыг Хороонд ирүүлэх;

3/ Энэхүү тушаалын 1-д заасан оноосон нэр өөрчлөгдсөн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, зохицуулалттай этгээдүүдэд болон арилжааны банкуудад хүргэж ажиллах;

4. Тушаалыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА











З.НАРАНТУЯА

001410

ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛЫН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Шийдвэрийн төслийн нэр: “Жавхланта хараа” ХК-ийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай

	Гарын үсэг:	Албан тушаал, нэр	Огноо:
1 Зөвшөөрсөн:		/СЗХ-ны дарга З.Нарантуяа/	2015/04/09
2 Танилцсан:		/СЗХ-ны гишүүн, дэд дарга Х.Бум-Эрдэнэ/	2015.07.27
		/СЗХ-ны гишүүн, дэд дарга Э.Батболд/	2015/07
3 Хянасан:		/Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэ/	2015.09.17
		/ЭЗХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Батгэрэл/	2015.7.7
		/БЗГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхбаяр/	2015.7.7
		/БЗГ-ын ХҮХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Төгс-Эрдэнэ/	2015/07
4 Төсөл боловсруулсан:		/БЗГ-ын ХҮХ-н хянан шалгагч Ч.Чулуунцэцэг/	2015/06/08

Санал:

Санал 1	Санал 2	Санал 3

Гарын үсэг, огноо

.....

Гарын үсэг, огноо







.....

Гарын үсэг, огноо

.....



Баримтын төрөл: Тогтоолын төсөл  
Огноо: 2015.07.06  
Хянасан: Ажлын албаны дарга  
ЭЗХ-ийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч  
Бүртгэл, зөвшөөрлийн газрын даргын  
үүргийг түр орлон гүйцэтгэгч  
БЗГ-ийн Хяналт, үйлчилгээний хэлтсийн  
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  
БЗГ-ийн ХҮХ-ийн ахлах  
хянан шалгагч  
Боловсруулсан: БЗГ-ын ХҮХ-ийн хянан шалгагч

 Б.Батсэлэнгэ  
 Н.Батгэрэл  
 Э.Мөнхбаяр  
 А.Төгс-Эрдэнэ  
 М.Тамир  
 Ч.Чулуунцэцэг

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны \_\_\_ сар \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

“Жавхлант хараа” ХК-ийн оноосон  
нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Е-Моние” ХК /Б.Мөнхбаяр/-д даалгасугай.

1/ Энэхүү тушаалын 1-д заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж Хороонд мэдэгдэх;

2/ Оноосон нэрийн өөрчлөлтийг ажлын хоёр хоногт багтаан хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутам хэвлэгдэн гардаг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, баримтыг Хороонд ирүүлэх;

3/ Энэхүү тушаалын 1-д заасан оноосон нэр өөрчлөгдсөн талаарх мэдээллийг Монголбанк, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, зохицуулалттай этгээдүүдэд болон арилжааны банкуудад хүргэж ажиллах;

4. Тушаалыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА



**“ЖАВХЛАНТ ХАРАА ХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ  
ӨӨРЧЛӨХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

“Жавхлант хараа” ХК нь оноосон нэрээ “Е-Моние” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 06/102 тоотой Хороонд ирүүлсэн бөгөөд тус ХК-иас ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж үзлээ.

**КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Сэлэнгэ аймгийн Жавхлан сумын нутагт байрладаг “Жавхлан хараа” ХК нь 1994 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн хувьцаат компани болсон.

1999 оноос үйл ажиллагаа нь бүрэн зогссон, татварын өртэй байсан тул татан буугдаагүй. 2005 оны 7 дугаар сард үйлдвэрийн агуулахад байсан дарь шатаж гал түймэр гарч хөрөнгө нь шатсан. Татварын өрийг төлөхгүй байсан тул Сэлэнгэ аймгийн татварын хэлтсээс “Жавхлант хараа” ХК-ийн өрийг төлүүлэх, татан буулгах нэхэмжлэлийг гаргасан. Сум дундын шүүхээс хэргийг хянаж үзээд шүүхийн 2011 оны 742 дугаартай шийдвэрээр уг ХК-ийг татан буулгахаар шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэрийг үндэслэн Хорооны 2013 оны 233 тоот тогтоолоор тус ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 58,543 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгээс хассан. “Жавхлант хараа” ХК-иас шүүхийн шийдвэрийг дахин хянан хэлэцүүлэхэр давж заалдсан, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан зэргийг шүүхээс хянаж үзээд 2013 оны 531 тоот шүүгчийн захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болсон.

Хорооны 2014 оны 246 тоот тогтоолоор “Жавхлант хараа” ХК-ийн бүртгэлийг сэргээхээр шийдвэрлэсэн байна.

Хувьцааны төвлөрлийг 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар харуулбал:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Хувь, хэмжээ	Хувьцаа эзэмшигчдийн тоо
1	О.Номин	11,690	19.97%	1
2	Н.Батчулуун	11,640	19.89%	1
3	Н.Нармандах	11,402	19.48%	1
4	П.Даваажав	10,117	17.28%	1
5	П.Дагвадорж	3,169	5.41%	1
6	Н.Батсайхан	3,121	5.33%	1
7	Б.Батболд	3,000	5.12%	1
8	Жижиг хувьцаа эзэмшигчид	4,404	7.52%	116
<b>Нийт</b>		<b>58,543</b>	<b>100.0%</b>	<b>123</b>

/ҮЦТТТХТ ХХК Хувь эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа/

**ИРҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ**

Тус компани нь 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлаас гарсан тогтоол шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Хороонд ирүүлсэн байна.

Монголын хөрөнгийн бирж ХК-иас “Жавхлант хараа” ХК нь МХБ-ийн “Бүртгэлийн журам” болон МХБ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт бүрэн бус ба 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар төлбөрийн ямар нэгэн тооцоогүй” гэсэн албан бичгийг, “ҮЦТТТХТ” ХК-иас тус ХК-ийг “хадгаламжийн болон мөнгөн хөрөнгийн төлбөрийн тооцоогүй” гэсэн тодорхойлолтыг тус тус ирүүлсэн.



Хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудсыг ирүүлсэн байна.

“Жавхлант хараа” ХК-иас оноосон нэр өөрчлөхөд төлөх зохицуулалт үйлчилгээний хөлс 500,000 төгрөгийг Санхүүгийн зохицуулах хорооны Төрийн сан банкин дахь 900025001 тоот дансанд 2015 оны 7 дугаар сарын 02-нд төвлөрүүлсэн байна.

#### **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН ДҮГНЭЛТ**

“Жавхлант хараа” ХК нь 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа Компанийн тухай хууль, Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зарлан хуралдуулсан байна.

Уг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 /хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх/-д заасан үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал болон гаргасан шийдвэрийг Хороонд хуульд заасан хугацаанд ирүүлсэн бөгөөд уг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон өөрчлөх талаар хэлэлцэж шийдвэрлэсэн тухай Хяналт шалгалтын газраас мэдэгдсэн.

#### **САНАЛ**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 /санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих/, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 20.1 /Нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах хэлбэрээр хувьцаат компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, нэмж үнэт цаас гаргах, хувьцааг хуваах, нэгтгэх, нийтэд санал болгон гаргасан компанийн бондын арилжаалагдаагүй үлдэгдлийг хүчингүй болгох болон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахад үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орно/ дэх заалтын дагуу “Жавхлант хараа” ХК-ийн оноосон нэрийг “Е-Моние” ХК болгон өөрчлөлт оруулах асуудлыг зөвшөөрөх тухай тушаалын төсөл, танилцуулгыг танилцуулж байна.

#### **ХЯНАСАН:**

БЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ..... Э.МӨНХБАЯР

БЗГ-ЫН ХҮХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ..... А.ТӨГС-ЭРДЭНЭ

БЗГ-ЫН ХҮХ-ИЙН  
АХЛАХ ХЯНАН ШАЛГАГЧ..... М.ТАМИР

#### **САНАЛ, ДҮГНЭЛТ БИЧСЭН:**

БЗГ-ЫН ХҮХ-ИЙН ХЯНАН ШАЛГАГЧ..... Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ



Г САНХҮҮГИЙН Г  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА З.НАРАНТУЯА  
ТАНАА

**ЖАВХЛАНТ ХАРАА ХК**  
ГАЗАР ТАРИАЛАН, ГАДААД ХУДАЛДАА  
2015 он 04 сар 10 өдөр  
Дугаар № 06/102

КОМПАНИЙ ОНООСОН НЭРЭНД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ТУХАЙ :

Манай компани нь 2015 оны 04 сарын 28 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар оноосон нэрэнд өөрчлөлт оруулан "Е-МОНИЕ" ХК болж байгаа билээ.

Иймд "КОМПАНИЙ ТУХАЙ" хуулийн 62.1.1-н дагуу компаний дүрэмд өөрчлөлт орж байгаа тул манай клмпаний оноосон нэрийн баталгаажуулалтын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХБАЯР

Утас 99022166

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг  
Далай цамхаг 9 давхар 906 тоот



**“ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 он 04 сар 28 өдөр

Дугаар:05

Улаанбаатар хот

**КОМПАНИЙ ОНООСОН НЭР  
ӨӨРЧЛӨЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2015 оны 04-р сарын 28 –ны  
нийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус  
хэлэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаний оноосон нэрийг цаашид явуулах үйл ажиллагаатай холбогдуулан  
“**Е-МОНИЕ**” ХК болгон өөрчлөн баталсугай
2. Компанийн нэрийн өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрсөний  
дараа компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай
3. Компаний нэрний өөрчлөлтийг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг  
болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**С.БАТБАЯР**

## Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас

Дугаар: 150504027

Огноо 2015.05.04

Бүртгэх байгууллагын нэр: Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

Хуулийн этгээдийн нэр	Нэр	Е моние
	Төрөл	Ашгийн төлөө
	Хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Удирдлагын Үүсгэн байгуулагчийн/	Ургийн овог	Боржигин
	Эцэг /эх/-ийн нэр	Энхбат
	Нэр	Цэндсүрэн
	Регистрийн дугаар	зю86022613
Өмчийн хэлбэр		Хувийн
Харьяалагдах дээд байгууллага		

Баталгаажуулалт хийсэн:

Улсын /ахлах/ бүртгэгч

У.Мандахтуяа

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулиас

3. Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн баталгаажуулснаас хойш ажлын 10 өдрийн дотоо улсын бүртгэлийн байгууллагад гаргана.  
4. Хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гаргалгүй бол хуулийн этгээдийн баталгаажуулалт хүчингүй болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг энэ хууль эргэлтээр гаргана.



## Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас

Дугаар: 150504027

Огноо: 2015.06.23

Бүртгэх байгууллагын нэр: Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

Хуулийн этгээдийн нэр	Нэр	Е моние
	Төрөл	Ашгийн төлөө
	Хэлбэр	Хувьцаат компани
Удирдлагын /Үүсгэн байгуулагчийн/	Ургийн овог	Боржигин
	Эцэг /эх/-ийн нэр	Энхбат
	Нэр	Цэндсүрэн
	Регистрийн дугаар	зю86022613
Өмчийн хэлбэр		Хувийн
Харьяалагдах татварын алба		Баянзүрх
Харьяалагдах дээд байгууллага		

Баталгаажуулалт хийсэн:

Улсын /ахлах/ бүртгэгч

..... / Ч.Батдэлгэр /

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулиас

14.3. Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

2/29



**БРОКЕР ДИЛЕРИЙН  
БУМБАТ-АЛТАЙ ХХК**

Friday, May 22nd, 2015  
Analyst: Shirendev Bajargal  
Mail: bumbataitai\_21@yahoo.com

**COMPANY PROFILE INFO**

**ЖАВХЛАНТ ХАРАА ХК (НСН:МО)**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

КОД: 408/ **Е-МОНИЕ/**  
ТЭМДЭГЛЭГЭЭ: НСН  
ЗЭРЭГЛЭЛ: МХБ-ийн III самбарт  
ЗАХИРАЛ: Б.Мөнхбаяр  
ТУЗ-ын ДАРГА: Ш.Батжаргал  
ХАЯГ: Сэлэнгэ аймаг  
Жавхлант сум  
УТАС: 976-99119822  
976-99022166  
СТАТУС: ХУВЬЦААТ КОМПАНИ

**САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ**

**НИЙТ ХӨРӨНГӨ:** (2013/09/30) **5 000 000 ₮**  
**ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ:** **5 000 000 ₮**  
**ДАНСНЫ ҮНЭ:** **85.40 ₮**  
**ТӨЛӨВЛӨСӨН IPO:** 20 ТЭРБУМ ₮  
**НЭРЛЭСЭН ҮНЭ:** 1000 ₮  
**НЭМЖ ГАРГАХ  
ХУВЬЦААНЫ ТОО :** 20,000,000.00 ширхэг  
**ЭХЛЭХ ХУГАЦАА:** 2015 ОНЫ 3 УЛИРАЛ  
**ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ  
БАЙРШИЛ :** НАЙЛАХ ДҮҮРЭГ

**ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ**

**НИЙТ ХУВЬЦАА:** 58 543 ш  
**ХААЛТЫН ХАНШ:** (2013/03/19) 151 ₮  
**ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ:** 8 839 993 ₮  
**ЖИЛИЙН ДУНДАЖ:** 151 ₮

**Компанийн тухай:** Жавхлант хараа ХК нь 1994 оны 04 сарын 01-нд Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэн хувьцаат компани болсон.

2015 оны ээлжит хурлын ХЭХ-ын 05 тогтоолоор “**Е-Моние**” ХК оноосон нэрэнд өөрчлөлт оруулсан

**Үйл ажиллагааны чиглэл:** Газар тариалан, Үр тариа бусад ургамал тариалалт, Хүнс, ундаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, Сүүний ферм

2015 оны ээлжит хурлын ХЭХ-ын 06 тогтоолоор үйл ажиллагааны чиглэлд өөрчлөн оруулан /**Шингэрүүлсэн шатдаг хий хадгалах болон бүрлуулах** / нэмэгдэв.

**Компанийн ХЭХ-ын тов:** Ээлжит бус хурал 2015 оны 4-р сарын 28-нд хуралдсан.

**Төлөвлөж буй ажил**

- ХЭХ-аас баталсан бизнес төлөвлөгөөний дагуу Компанийг капиталжуулан үнэлгээ хийлгэх.
- Нэмж хувьцаа гаргах Төслийг СЗХ-ны хурлаар оруулан танилцуулах

**СЗХ -танилцуулах**

1. Оноосон нэрэнд өөрчлөлт оруулах
2. Хуулийн этгээдийн бүртгэл шилжүүлэх
3. СЗХ-нд 14640 ширхэг 25% хувьцаа эзэмшигч нар хөрөнгөө авсан учир хувьцааг халааслах
4. Нэмж хувьцаа гаргах төслийг батлуулах
5. Компаний засаглал болон СЗХ-д хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах

**ТУЗ-ийн гишүүд:**

ТУЗ-ийн дарга: Ширэндэв БАТЖАРГАЛ  
ТУЗ-ийн гишүүд: Батбаяр МӨНХБОЛОР  
Батбаяр МӨНХБАЯР  
Батбаяр МӨНХБАТ  
Батбаяр МӨНХБОЛД  
Сосорбурам БАТБАЯР  
Хараат бус гишүүд: Энхбат ЦЭНДСҮРЭН  
Төмөрбаатар Наранхүү  
Жаргалсайхан УНДРАА

**Нийт хувьцаа эзэмшигчид:**

1. Б.МӨНХБОЛОР - <sup>Төгсөв</sup> 39499 ширхэг 67.47%
2. СЗХ-нд 14640 ширхэг 25% хүмүүс хөрөнгө авсан учир хувьцааг халааслах
3. ХОЭБ-ээрх 117 хүн 7.53%